



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 4/46

Мандалговь

“Шаардлага хангасан сайжруулсан түлшний  
үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх /Дундговь/” ажлын гүйцэтгэгчийг  
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх /Дундговь/” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)
Гишүүд:	Н.Мэндсайхан (Иргэний төлөөлөл) Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга) Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга)
Нарийн бичиг:	Э.Мөнхцацрал (Орон нутгийн өмчийн Газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Мөнхцацрал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



3910510087